



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2014 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 68

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Төсвийн тухай хууль, Сангийн яамнаас батласан холбогдох стандарт, дүрэм, журам, зааврыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

Нэг. Байгууллагын санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор “Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Алтансүх

Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга

Гишүүд:

Б.Төмөрхүү

Харилцаа холбоо, дэвшилтэт технологийн ажлын албаны дарга

Р.Алтангэрэл

Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн

Л.Батбаяр

Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн

Нарийн бичиг дарга:

Э.Хонгорзул

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албаны нягтлан бодогч

Хоёр. Тус газрын нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү бүртгэлийн холбогдох хууль журамд нийцүүлэн боловсруулж, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг тусган 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсэг /Б.Алтансүх/-т даалгасугай.

ДАРГА

Ц.ЖАДАМБАА

110753